

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ТҮНТ-ИЙН  
2022 ОНЫ 09 ДУГААР САРЫН 02-08-НЫ  
ӨДРҮҮДЭД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2022 оны 09 дугаар сарын 08

Хэрлэн сум

Өргөдөл гомдол санал хүсэлтийн мэдээлэл: 705631111 утсанд Өндөрхаан хорооллын хойд талд үхэр ихтэй айл бууж төв гудамжаар их бэлчиж байна гэсэн дуудлага 2, С-79-р байранд ус алдаж байгаа засварлуулах хүсэлт, Засгийн газрын 1111 төвд төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой 1 БСШУГазар, Бор-Өндөр сумын газар зохион байгуулалтын тухай 1, Биндэр суманд эрт илрүүлгийн үзлэг 2 хоног хийсэн нь хүн ам ихтэй суманд шинжилгээнд хамрагдаагүй хүн олон байгаа тул дахин сумандаа хамрагдах хүсэлт ирүүлсэн байна. Шийдвэрлүүлж хариу өгсөн 2, шийдвэрлэлтийн шатандаа судлагдаж байгаа 3 байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нийт 774 иргэн үйлчлүүлж Утсаар 62, цахимар 20, өөртөө үйлчлэх танхимаар 225, Үүнээс биечлэн 467 иргэн үйлчлүүлснээс. Улсын бүртгэлээр 224, Газрын харилцаагаар 10, Хөдөлмөр халамжийн үйлчилгээгээр 115, Нотариатаар 63, Өндөрхаан БДК -5, Төрийн банкаар 30, e-mongolia сурталчилах цэгээр 15, E-khutuch.mn булангаар 5, /цахим дэлгэцээр 25 / иргэн үйлчлүүлсэн. Халамжаар 9-р сард түлээ нүүрсний хөнгөлөлт өгч байгаатай холбоотой, Улсын бүртгэлээр шилжилт хөдөлгөөн, иргэний үнэмлэх олголтын үйлчилгээг иргэд олноор үйлчлүүлсэн байна.

Үнэлгээний төхөөрөмжинд 467 үнэлгээ өгөгдсөнөөс: Маш сайн 456, сайн 2, дунд 9 байна.